



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 9 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 282

Улаанбаатар
ХОТ

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бүүвэйбаатар овогтой Ундрааг Швейцари улсын Женев хотын Олон Улсын Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Сандагдорж овогтой Төгөлдөр, Доржгүрхэм овогтой Энхбат нарыг бизнесийн удирдлагын чиглэлээр, Рэнчиндорж овогтой Чингис, Жадамбаа овогтой Ганбаатар нарыг эрүүгийн эрх зүйн чиглэлээр, Дашзэгвэ овогтой Оргилтуяаг байгаль орчны чиглэлээр, Цагаанхүү овогтой Дэлгэрмааг антропологийн чиглэлээр, Наваанцэдэн овогтой Энхбатыг төрийн захиргааны чиглэлээр, Төгсмандал овогтой Цэцэнг эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр тус тус АНУ-ын Денвер хотын Колорадогийн Их сургуулийн магистрантурт 2 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД *Tsaminda* А.ЦАНЖИД

Хуучин үгт ст. В. Энхтөрөл. 2001.9.3